



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/25/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Их монгол хөлөг аудит ХХК
Захирал С.Тунгалаг
Цахим хаяг: info@imkaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	14
7. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ	14
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Зөвлөмж	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Х.ПҮРЭВЖАРГАЛ
ТАНАА

2022.03.15 № 09/572
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд нийт орлогыг 5,620.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,056.5 сая төгрөгөөр, ашгийг 564.3 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 4,126.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,586.6 сая төгрөгийн зардал гарган, 459.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,391,456,642.70	1,596,953,175.89
1.1.02	Дансны авлага	599,517,635.50	541,726,087.81
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	84,503,548.39
1.1.06	Бараа материал	178,747,551.33	248,234,909.93
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	52,200,000.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,221,921,829.53	2,471,417,722.02
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,346,021,621.82	5,547,067,326.56
1.2.02	Биет бус хөрөнгө	833,281,190.52	858,923,757.04
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,179,302,812.34	6,405,991,083.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,401,224,641.87	8,877,408,805.62
2.1.1.01	Дансны өглөг	78,484,536.54	204,331,788.63
2.1.1.03	Татварын өр	153,289,665.29	-
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	13,340,383.58
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	231,774,201.83	217,672,172.21
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	861,956,082.92	775,245,779.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	861,956,082.92	775,245,779.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,093,730,284.75	992,917,951.21
2.3.01	Өмч: - төрийн	1,012,811,105.36	1,012,811,105.36
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	870,556,471.43	1,100,002,527.45
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,287,204,708.49	2,304,832,319.44
2.3.09	Хуримтлагдсан ашиг	4,136,922,071.84	3,466,844,902.16
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(459,758,124.68)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	4,136,922,071.84	3,926,603,026.84
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,307,494,357.12	7,884,490,854.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,401,224,641.87	8,877,408,805.62

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	5,639,604,371.32	4,028,393,735.50
02	Борлуулалтын өртөг	4,594,515,310.05	4,327,756,707.24
03	Нийт ашиг(алдагдал)	1,045,089,061.27	(299,362,971.74)
04	Түрээсийн орлого	-	-
05	Хүүний орлого	43,913,880.94	-
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	169,196,803.88	98,365,377.92
08.1	Орлогын дүн	213,110,684.82	98,365,377.92
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	182,766,421.14	244,679,135.26
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	109,128,042.74	13,039,312.06
12.1	Зардлын дүн	291,894,463.88	257,718,447.32
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(52,416.54)	(1,042,083.54)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
17.1	Олз, гарзын дүн	(52,416.54)	(1,042,083.54)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	966,252,865.67	(459,758,124.68)
19	Орлогын татварын зардал	129,822,969.44	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	836,429,896.23	(459,758,124.68)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	836,429,896.23	(459,758,124.68)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,012,811,105.36	870,556,471.43	911,001,468.49	3,420,972,175.61	6,215,341,220.89
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	1,012,811,105.36	870,556,471.43	911,001,468.49	3,420,972,175.61	6,215,341,220.89
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	836,429,896.23	836,429,896.23
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	376,203,240.00	-	376,203,240.00
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	(120,480,000.00)	(120,480,000.00)
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
09	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,012,811,105.36	870,556,471.43	1,287,204,708.49	4,136,922,071.84	7,307,494,357.12
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	1,012,811,105.36	870,556,471.43	1,287,204,708.49	4,136,922,071.84	7,307,494,357.12
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(459,758,124.68)	(459,758,124.68)
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,017,627,610.95	-	1,017,627,610.95
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(210,319,045.00)	(210,319,045.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	229,446,056.02	-	-	229,446,056.02
17	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,012,811,105.36	1,100,002,527.45	2,304,832,319.44	3,466,844,902.16	7,884,490,854.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,260,226,962.75	4,761,105,966.80
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,111,808,581.84	4,485,302,638.88
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	24,087,402.00	12,033,535.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	124,330,978.91	263,769,792.92
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,312,959,848.02	5,211,502,101.15
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,145,879,817.54	2,360,900,246.36
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	551,469,619.12	603,032,703.87
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	459,200,199.00	189,075,101.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	444,628,564.92	301,038,023.83
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	364,376,905.00	353,719,622.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	3,179,716.86	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	732,669,683.73	770,735,753.18
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	445,500.00	2,621,960.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	611,109,841.85	630,378,690.91
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	947,267,114.73	(450,396,134.35)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	43,913,880.94	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	43,913,880.94	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	71,100,900.00	1,305,464,342.46
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	52,710,900.00	122,892,850.01
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	18,390,000.00	30,222,835.45
2.2.6	Бусад	-	1,152,348,657.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(27,187,019.06)	(1,305,464,342.46)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	165,480,000.00	38,642,990.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	165,480,000.00	38,642,990.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(165,480,000.00)	(38,642,990.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	754,600,095.67	(1,794,503,466.81)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,636,856,547.03	3,391,456,642.70
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,391,456,642.70	1,596,953,175.89

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2020 оны гүйцэтгэл	2021 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Авто замын барилгын ажлын техник, технологийн хяналт	Мян.төг	1,826,899.8	1,858,990.0	1,201,412.2	(657,577.8)	64.6
	Авто замын засвар арчлалт хариуцсан компаниудын техник, технологийн хяналт	Мян.төг	838,204.5	1,544,970.3	802,030.5	(742,939.8)	51.9
	Лабораторийн сорил шинжилгээний ажил, тоног төхөөрөмжийн түрээс, замын чанар, байдлын судалгаа, дүгнэлт	Мян.төг	1,038,058.2	578,000.0	528,291.1	(49,708.9)	91.4
	Техник ашиглалтын түвшин тогтоох ажил	Мян.төг	213,152.6	253,021.9	146,806.5	(106,215.4)	58.0
	Хөдөлгөөний эрчмийн судалгаа	Мян.төг	136,545.5	150,000.0	92,681.8	(57,318.2)	61.8
	Эрдэм шинжилгээ судалгаа, стандарт, норм дүрэм боловсруулах	Мян.төг	118,923.9	100,800.0	130,093.9	29,293.9	129.1
	Зураг төсөл төсвийн экспертизийн үйл ажиллагаа	Мян.төг	757,009.4	388,000.0	696,438.4	308,438.4	179.5
	Төлбөр хураах цэгээс ЗХЗ, бусад орлого	Мян.төг	333,110.7	140,000.0	93,700.4	(46,299.6)	66.9
	Төсөл арга хэмжээний орлого	Мян.төг	590,810.7	607,000.0	435,304.2	(171,695.8)	71.7
2	Нийт орлого	Мян.төг	5,852,715.1	5,620,782.2	4,126,759.1	(1,494,023.1)	73.4
3	Нийт зардал	Мян.төг	4,886,409.8	5,056,464.2	4,586,517.2	(469,946.9)	90.7
	Үүнээс: Удирдлагын зардал	Мян.төг	182,766.4	252,403.1	286,614.6	34,211.5	113.6
4	Татварын өмнөх ашиг	Мян.төг	966,305.3	564,318.0	(459,758.1)	(1,024,076.2)	(81.5)
5	Цэвэр ашиг /алдагдал/	Мян.төг	836,429.9	507,886.2	-	(507,886.2)	-
6	Төсвийн төлбөрт нийт дүн	Мян.төг	1,462,384.8	68,384.5	1,128,713.4	1,060,328.9	1,650.5
7	Төрийн өмчийн ногдол ашиг	Мян.төг	83,643.0	76,182.9	-	(76,182.9)	-
8	Нийт ажиллагсадын тоо	Хүн	148	137	134	(3)	97.8
9	Нийт цалингийн сан	Мян.төг	2,712,522.3	2,934,892.9	2,990,309.6	55,416.7	101.9

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

10	Нэг ажилтны дундаж цалин	Мян.төг	1,295.8	1,346.4	1,346.4	-	100.0
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	Мян.төг	0.0	0.0	0.0	0.0	123.5
12	Хөрөнгө оруулалт	Мян.төг	71,100.9	2,366,328.2	1,312,664.3	(1,053,663.9)	55.5
13	Нийт авлага	Мян.төг	599,517.6	218,988.0	626,229.6	407,241.6	286.0
	Үүнээс: Найдваргүй	Мян.төг	-	76,500.0	-	(76,500.0)	-
14	Нийт өглөг	Мян.төг	1,174,194.8	793,903.6	992,918.0	199,014.4	125.1
	Богино хугацаат өр төлбөр	Мян.төг	312,238.7	99,131.4	217,672.2	118,540.8	219.6
	Урт хугацаат өр төлбөр	Мян.төг	861,956.1	694,772.2	775,245.8	80,473.6	111.6

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөөжөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төлбөрийн и баримт, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын15-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, туслах аудитор Г.Ариунболд, Б.Ган-Эрдэнэ,Т.Оюун нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Сожидмаа, захирал С.Тунгалаг нар тус тус хэрэгжүүлсэн.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/128 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Зам тээврийн хөгжлийн яамны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас шилэн данстай холбоотой шалгалт хийсэн боловч шалгалтын тайланг ирүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан зорилтот түвшний нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан зорилтот түвшний нийт зардлын 5,056.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 50.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын зорилго нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгө ашиглалтын эрх, түүнийг өөрчлөн зохион байгуулах, бүрэлдэхүүнтэй холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино гэж тодорхойлжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна.

Үйлдвэрийн газрын дүрэмд үүсгэн байгуулагч нь Засгийн газар байх бөгөөд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар байна гэж тодорхойлжээ.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 55 дугаар тогтоолоор байгуулагдаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 126 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан дүрмийн хүрээнд тус тогтоолоор батлагдсан бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

"Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 613 тоот тогтоолоор “2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталж, 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Зам тэврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захиралтай 2021/24к дугаар контракт гэрээг байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар

хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, зардлыг хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай";
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам";
- Хөдөлмөрийн тухай хууль /2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх/;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ХӨРӨНГӨ			-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,391,456.6	1,596,953.2	(1,794,503.4)
Авлага	599,517.6	626,229.6	26,712.0
Бараа материал	178,747.6	248,234.9	69,487.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	52,200.0	-	(52,200.0)
Үндсэн хөрөнгө	3,346,021.6	5,547,067.3	2,201,045.7
Биет бус хөрөнгө	833,281.2	858,923.8	25,642.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,401,224.6	8,877,408.8	476,184.2
Өр төлбөрийн дүн	1,093,730.3	992,917.9	(100,812.4)
Эздийн өмчийн дүн	7,307,494.3	7,884,490.9	576,996.6
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,401,224.6	8,877,408.8	476,184.2

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 1,596.7 сая төгрөг, кассад 0.3 сая төгрөг байна.

Авлагын 626.3 сая төгрөгийн үлдэгдэлд ХХОАТ-ын авлага 23.6 сая төгрөг, НӨАТ-ын авлага 60.9 сая төгрөг, дансны авлага 541.8 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд цалин хөлснөөс татвар илүү суутган төлснөөс 23.6 сая төгрөгийн ХХОАТ-ын авлага, борлуулалтын үйл ажиллагаанаас үүссэн НӨАТ-ын авлага 60.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 69.5 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын нөөц нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардлын данс 52.2 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн ногдол ашигт 45 сая төгрөг, бараа материалын худалдан авалтын урьдчилгаанд 7.2 сая төгрөгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,201.0 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Дуусаагүй барилгын дансанд 1,152.3 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийн дансанд хурдны замын засвар арчлалтад зориулж ТӨБЗГ-ын 2021 оны А-1/832 тоот албан бичгийн дагуу 898.8 сая төгрөгийн машин механизм, төслийн 196.0 сая төгрөгийн 2 суудлын автомашиныг бүртгэлд тусгасан.

Өр төлбөрийн дүн 100.8 сая төгрөгөөр буурсан нь урт хугацаат өр төлбөрийг орлогын аргаар бүртгэж, тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрсөн.

Эздийн өмчийн дүн 577.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2021 оны А-1/832 тоот албан бичгийн дагуу 898.8 сая төгрөгийн машин механизм, төслийн 196.0 сая төгрөгийн 2 суудлын автомашиныг хүлээн авсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 613 дугаар тогтоолоор Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 5,620.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,056.5 сая төгрөгөөр, 564.3 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,366.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 4,126.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,586.5 сая төгрөгийн зардал гарган 459.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,126.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,494.0 сая төгрөг буюу 26.6 хувиар тасарсан нь ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас барилга угсралтын ажлын гадаад материалын татан авалтын хугацаа, гадаад ажиллах хүчний орж ирэх хугацаа хойшилж, зарим ажлууд тайлант хугацаанд дуусаагүй нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,586.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 470.0 сая төгрөг буюу 9.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь орлогын төлөвлөгөө 26.6 хувиар тасарснаас шууд хамааралтай байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 171 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь тайлант хугацаанд нийт 175 мэдээллийг байршуулахаас 144 мэдээллийг бүрэн байршуулж, 4 мэдээлэл хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7 удаагийн гүйлгээ,

зарлагын 13 удаагийн 441.3 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ, 7 удаагийн тендерийн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд нийт орлогыг 5,620.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,056.5 сая төгрөгөөр, ашгийг 564.3 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 4,126.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,586.5 сая төгрөгийн зардал гарган, 459.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, орлогын төлөвлөгөөг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох зарим заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар 64.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 41.5 сая төгрөгийг залруулж, 11.2 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, 12.1 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	11,688.0	2	11,688.0	-	-	100
Зөвлөмж	4	14,412.0	4	14,412.0	-	-	100
Нийт дүн	6	26,100.0	6	26,100.0	-	-	100

7. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын өргөтгөлийн барилгын гүйцэтгэл, томилолтын тооцоо, хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлсэн байгууллагын дотоод журмыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,267.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,237.4 сая төгрөгийн алдааг залруулж, 17.2 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 12.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 30.0 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 50.6 сая төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 2,237.4 сая төгрөгийн 10 алдааг залрууллаа. Үүнд:

- Тайлант хугацаанд 215 удаагийн 266.1 сая төгрөгийн ажил гүйлгээг шууд зардлын дансанд бүртгэсэн;
- Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тайланг (ТТ-11-1) 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 750.7 сая төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн;
- Дуусаагүй барилгын 1,141.1 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн;
- Санхүүгийн тайлангийн тодруулгад нийгмийн даатгалын байгууллагаас авах авлагыг 25.8 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын дансанд 26.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн;
- Тавилга эд хогшлын дансанд 5.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.5 сая төгрөгийн бараа материал бүртгэсэн;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан ашиглалтын жилийн зөрүүгээс 7.9 сая төгрөгийн элэгдэл илүү байгуулсан;
- Хувь хүний орлогын албан татварын элэгдлийг 1.0 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон;
- Зураг төслийн баримт бичигт магадлал хийх гэрээний 12.0 сая төгрөгийг орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнаагүй.

8.2 Төлбөрийн акт

1. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгохдоо захирлын 2021 оны Б/93 тоот тушаалд заасан ажил хавсарсны нэмэгдэл тооцох хувь хэмжээг илүү тооцоноос 1 ажилтанд 0.09 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2020 оны 126 тоот тогтоолоор баталсан зорилтот түвшинд заасан орон тоог хэтрүүлэн 2 ажилтанд 4.1 сая төгрөг, нийт 4.2 сая төгрөг илүү олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно”, Монгол улсын засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 11.5-д “Ажил орлосон болон хавсарсан гүйцэтгэсэн ажилтан зохих ажлыг бүрэн хариуцах ба орлон ажилласан ажилтанд үндсэн цалингаас нь тооцон 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлсийг төвийн захирлын тушаалаар олгож болно” гэж заасантай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Тайлант онд 4 ажилтанд 0.2 сая төгрөгийн зэргийн нэмэгдэл илүү тооцож олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д “Ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоон олгоно”, газрын Хамтын гэрээний 3.9-д “Ажилтны

ажилласан жилийн нэмэгдлийг дараах хувь хэмжээгээр бодож олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Тайлант онд 95 албан хаагчдад олгосон үйл ажиллагааны орлогоос 0.7 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.4 дахь заалт "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

4. Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын хавсралт-1 "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөөгүйн улмаас 34 ажилтанд нийт 12.1 сая төгрөгийн шатахууны зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх заалт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд кассаас 0.1 сая төгрөг, харилцахаас 1.3 сая төгрөг, нийт 1.4 сая төгрөгийн 10 удаагийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу анхан шатны баримтад үндэслэн хөтөлж, ажил гүйлгээг бүртгэж байх.

2. Төлбөрийн баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Давхардсан тоогоор 76 иргэн, хуулийн этгээдтэй холбоотой нийт 11.3 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа төлбөрийн И-баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж

ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа төлбөрийн баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Тайлант онд мөнгөн гүйлгээнээс шууд зардалд бичсэн ажил гүйлгээнээс 100.0 мянган төгрөгөөс дээш ажил гүйлгээнээс түүвэр хийхэд нийт 266,093.7 мянган төгрөгийн 215 ширхэг гүйлгээ хийгдсэн байна.	Залруулсан	1	266,093.7	1	266,093.7	-	-	-	-	-	-	-	-
2	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Байгууллагын 1-12 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй журналыг татварын цахим тайланд илгээсэн хувь хүний орлогын албан татварын тайлан (ТТ-11-1)-тай тулгаж үзэхэд 117.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	Залруулсан	1	117.3	1	117.3	-	-	-	-	-	-	-	-
3	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Санхүүгийн байдлын тайлангийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны эцсийн үлдэгдэл 1,114,055.6 мянган төгрөг боловч үндсэн хөрөнгийн	Залруулсан	1	750,654.8	1	750,654.8	-	-	-	-	-	-	-	-

			дэлгэрэнгүй бүртгэлээр эцсийн үлдэгдэл 1,864,710.3 мянган төгрөг байна. Зөрүү 750,654.8 мянган төгрөгийн зөрүүтэй байна.															
4	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Барилга барих гэрээний дагуу Ай Ди Си Проперти ХХК-нд төлсөн 1,141,059.2 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд илэрхийлсэн байна.	Залруулсан	1	1,141,059.2	1	1,141,059.2	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайлангийн тодруулгаар нийгмийн даатгалын байгууллагаас 25,801.9 мянган төгрөгийн авлагатай гэж илэрхийлсэн боловч нийгмийн даатгалын байгууллагаас авлагагүй байна	Залруулсан	1	25,801.9	1	25,801.9	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын дансны эхний үлдэгдэлд 26,427.3 мянган төгрөгийн 3 ширхэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бүртгэсэн байна.	Залруулсан	1	26,427.3	1	26,427.3										
7	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Тавилга эд хогшлын дансанд 5,885.6 мянган төгрөгийн 11 тоног төхөөрөмж, 510.0 мянган төгрөгийн 3 ширхэг бараа материал, нийт 14 ширхэг 6,395.6	Залруулсан	1	6,395.6	1	6,395.6	-	-	-	-	-	-	-	-	-	-

			мянган төгрөгийн хөрөнгө нэр ангилал, данс зөрүүтэй бүртгэсэн байна.															
8	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Нийт 21 ширхэг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээрх ашиглалтын жил нь байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан ашиглалтын жилүүдтэй зөрүүтэй улмаас 7,902.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцоолсон байна.	Залруулсан	1	7,902.8	1	7,902.8	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 27 ажилтанд 722.0 мянган төгрөгийн илүү, 30 ажилтанд 223.9 мянган төгрөгийг дутуу, нийт 945.9 мянган төгрөгийн хөнгөлөлтийг зөрүүтэй эдлүүлсэн байна.	Залруулсан	1	945.9	1	945.9	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Тайлант жилд 2 байгууллагатай Зураг төслийн баримт бичигт магадлал хийх гэрээ байгуулсан боловч 12,010.8 мянган төгрөгийн орлогыг гэрээт ажлын орлогоор бүртгэлд тусгаагүй байна.	Залруулсан	1	12,010.8	1	12,010.8	-	-	-	-	-	-	-	-	-	-

1 1	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Ажил хавсарсны нэмэгдэл цалинг олгохдоо Захирлын 2021 оны 07 сарын 08-ны өдрийн Б/93 тоот тушаалд заасан ажил хавсарсны нэмэгдэл тооцох хувь хэмжээг илүү тооцоноос 1 ажилтанд 92.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2020 оны 4 сарын 21-ний өдрийн 126 тоот тогтоолоор баталсан Зорилтот түвшинд заасан орон тоог хэтрүүлэн 2 ажилтанд 4,142.4 мянган төгрөг, нийт 4,234.4 мянган төгрөг илүү олгосон байна.	Төлбөрийн акт тогтоох	1	4,234.4	-	-	1	4,234.4	-	-	-	-	-
1 2	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Тайлант онд зэргийн нэмэгдэл тооцож олгохдоо 4 ажилтанд 149.5 мянган төгрөгийг илүү олгосон байна.	Төлбөрийн акт тогтоох	1	149.5	-	-	1	149.5	-	-	-	-	-
1 3	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Тайлант онд 95 албан хаагчдад олгосон үйл ажиллагааны орлогоос 739.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.	Төлбөрийн акт тогтоох	1	739.0	-	-	1	739.0	-	-	-	-	-
1 4	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын хавсралт-1 "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун	Төлбөрийн акт тогтоох	1	12,129.9	-	-	1	12,129.9	-	-	-	-	-

			зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөөгүйн улмаас 34 ажилтанд нийт 12,129.9 мянган төгрөгийн шатахууны зардлыг илүү олгосон байна.														
1 5	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Кассаас 46.6 мянган төгрөг, харилцахаас 1,336.0 мянган төгрөг, нийт 1,382.6 мянган төгрөгийн 10 удаагийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.	Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу анхан шатны баримтад үндэслэн хөтөлж, ажил гүйлгээг бүртгэж байх	1	1,382.6	-	-	-	-	-	-	-	-	1	1,382.6	
1 6	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Давхардсан тоогоор 76 иргэн, хуулийн этгээдтэй холбоотой нийт 11,284.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа төлбөрийн И-баримтаар баталгаажуулаагүй байна.	Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж,	1	11,284.2	-	-	-	-	-	-	-	-	1	11,284.2	

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

				бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа төлбөрийн баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх													
Дүн					16	2,267,328.8	10	2,237,409.2	4	17,252.8	-	-	-	-	2	12,666.8	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																	
1	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд 4 мэдээлэл хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7 удаагийн гүйлгээ, зарлагын 13 удаагийн 441,245.6 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, 7 удаагийн тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг байршуулаагүй байна.	Хариуцлага тооцох Албан шаардлага өгөх	1	441,245.6	-	-	-	-	1	441,245.6	1	441,245.6	-	-	
2	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	АХГ-2022/25/НА-СТА-ТӨА	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 613 дугаар тогтоолоор баталсан 2021 оны орлогын төлөвлөгөөг 1,494,023.1 мянган төгрөгөөр буюу 22.6 хувиар тасарсан байна.	Албан шаардлага	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	
Дүн					2	441,245.6	-	-	-	-	2	441,245.6	1	441,245.6	-	-	
НИЙТ ДҮН					18	2,708,574.4	10	2,237,409.2	4	17,252.8	2	441,245.6	1	441,245.6	2	12,666.8	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 87/А.0150458
АХГ-2022/25/НА-СТА-Т0А

Улаанбаатар хот

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 95 албан хаагчдад олгосон үйл ажиллагааны орлогоос 739,000.00 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй 739,000.00 /Долоон зуун гучин есөн мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргал, нягтлан бодогч Б.Дуламханд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.АРИУНБАТ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 86/ХО150458
АХГ-2022/25/НА - СТА - ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 4 ажилтанд 149,499.00 төгрөгийн зэргийн нэмэгдэл илүү тооцож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 "Ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоон олгоно", Хамтын гэрээний 3.9-д "Ажилтны ажилласан жилийн нэмэгдлийг дараах хувь хэмжээгээр бодож олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тайлант онд зэргийн нэмэгдэл тооцож олгоходоо 4 ажилтанд 149,499.00 /Нэг зуун дөчин есөн мянга дөрвөн зуун ерэн есөн/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргал, нягтлан бодогч Б.Дуламханд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Б.АРИУНБАТ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 85/АО/50458
АХГ-2022/25/НА-СТА-70А

Улаанбаатар хот

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөөгүйн улмаас 34 ажилтанд нийт 12,129,900.00 төгрөгийн шатахууны зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Шатахууны зардлын илүү тооцсон 12,129,900.00/Арван хоёр сая нэг зуун хорин есөн мянга есөн зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргал, нягтлан бодогч Б.Дуламханд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ГАРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 84/А.0150458
АХГ-2022/05/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалинг олгохдоо захирлын 2021 оны Б/93 дугаар тушаалд заасан ажил хавсарсны нэмэгдэл тооцох хувь хэмжээг илүү тооцсоноос 1 ажилтанд 92,000.00 төгрөг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 126 дугаар тогтоолоор баталсан зорилтот түвшний төлөвлөгөөнд заасан орон тоог хэтрүүлэн 2 ажилтанд 4,142,396.00 төгрөг, нийт 4,234,396.00 төгрөг илүү олгосон байна.


Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 11.5 "Ажил орлосон болон хавсарсан гүйцэтгэсэн ажилтан зохих ажлыг бүрэн хариуцах ба орлон ажилласан ажилтанд үндсэн цалингаас нь тооцон 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлсийг төвийн захирлын тушаалаар олгож болно" гэж заасантай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон нэмэгдэл цалин 4,234,396.00 /Дөрвөн сая хоёр зуун гучин дөрвөн мянга гурван зуун ерэн зургаан/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргал, нягтлан бодогч Б.Дуламханд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 416/А0150458
АХГ-2022/25/КА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 564,318,040.00 төгрөгийн ашигтай байхаар баталсан нь гүйцэтгэлээр 459,758,124.68 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргатай байгуулсан гэрээний дагуу зорилтот түвшний хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргал, нягтлан бодогч Б.Дуламханд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны _____ дугаар сарын _____

№ 717/А.0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/25/НА-СТА-ТӨА

「 Сахилгын хариуцлага тооцуулах тухай 」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд нийт 171 мэдээллийг байршуулахаас 144 мэдээллийг бүрэн байршуулж, 4 мэдээлэл хугацаа хоцорч, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 7 удаагийн гүйлгээ, зарлагын 13 удаагийн 441,245,636.25 төгрөгийн мөнгөн гүйлгээ, 7 удаагийн тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Өмнөх аудитаар шилэн данс хөтлөлттэй холбоотой өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй нягтлан бодогч Б.Дуламхандад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргал даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

B. Puv
C. Dy
G. Ariunbat

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.АРИУНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.20 Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-106.Docx

0016831200

